



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/170

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нисэхийн аюулгүй байдал, хамгаалалтын албаны тусгай зориулалтын нохойн хоол нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны  
дарга:

О.Ууганбаатар  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа  
Нисэхийн аюулгүй байдал, хамгаалалтын  
албаны Төлөвлөлт, сургалт дадлагын хэсгийн  
дарга)

Гишүүд:

Х.Мөнхтулга  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа  
Нисэхийн аюулгүй байдал, хамгаалалтын  
албаны Хамгаалалтын хэсгийн дарга)

М.Оргил  
("Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв"  
Төрийн бус байгууллагын гишүүн  
(тохиролцсоноор))

Х.Мөнхбаяр  
("Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөл" Төрийн  
бус байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

Нарийн бичиг:

Э.Уянга  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө

1120 0512

оруулалт, захиалагчийн албаны Худалдан  
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

2.Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (О.Ууганбаатар)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, хууль, эрх зүйн хэлтэс (З.Туяа), Иргэний нисэхийн үндэсний төв (Э.Төрбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанд хүргүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Э.Уянга)-т даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА